



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2011 оны
2-р сар

Нийгмийн даатгалын санд 2011 оны эхний 2 сарын байдлаар нийт **63,7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 123.8 хувиар биелүүлсэн байна. Даатгалын сангаас давхардсан тоогоор 556,4 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж үйлчилгээний зардалд нийт 90,7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 1,6 тэрбум төгрөг мvc мvc зарцуулжээ.**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

2011 оны эхний 2-р сард нийгмийн даатгалд

- заавал даатгуулагч 329,3 мянга
- сайн дурын даатгуулагч 22,5 мянга.
- эрүүл мэндийн даатгалд 1203,7 мянган даатгуулагч хамрагдсан байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын таван төрлийн санд энэ оны 2-р сард 34,1 тэрбум төгрөгийн шимтгэл төвлөрүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0 тэрбум төгрөгөөр өсчээ.

1-2 саруудад жилийн төлөвлөсөн орлогын **14.4** хувийг оруулаад байгаа бөгөөд ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого дараахь байдлаар сангуудад хуваарилагдсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 63.0% буюу 40.1 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 4.5% буюу 2,9 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 7.3% буюу 4,7 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 4.2 % буюу 2,7 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 21.0% буюу 13,3 тэрбум төгрөг.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2011 оны 2-р сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 31.6 тэрбум төгрөг зарцуулжээ. Жилийн нийт төлөвлөсөн зардлын 15,0 хувь буюу 90.7 тэрбум төгрөгийг оны эхний хоёр сарын байдлаар зарцуулсан байна.


Тэтгэврийн даатгалын сан

Эхний 2 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 296,4 мянган иргэдийн тэтгэвэрт 72.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт зардлын 73.5 хувь буюу 52.9 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэрт зарцуулжээ.


Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



Тэтгэврийн даатгалын сангийн зардал /Тэрбум төгрөгөөр/



Тэтгэмжийн даатгалын сангийн зардал /сая төгрөгөөр/



Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 18.1 мянган иргэнд 3.5 тэрбум төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оны 2-р сараас 0.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт зардлын 62.4 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулжээ.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 6,5 мянган тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 2880,1 сая төгрөг, 167 хүнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрт нийт 66,4 сая төгрөгийг тус тус зарцуулав.

Ажилгүйдлийн даатгалын сан

2011 оны 2 сарын мэдээгээр ажилгүйдлийн даатгалын сангаас 1512,0 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, сургалтын зардалд зарцуулсан нь 2009 оны мөн үетэй харьцуулахад 31,9 хувиар буюу 371,1 сая төгрөгөөр нэмэгджээ.

Эрүүл мэндийн даатгалын сан

Тухайн сард эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардалд 10,7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт зардлын 95,4 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээний зардалд, 1.8 хувийг рашаан сувилалд, 2.8 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхнээс 2,4 тэрбум төгрөгөөр өсч 17,3 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт шимтгэлийн авлагын 91,9 хувийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байгаа бөгөөд авлагын хэмжээ өмнөх сараас 2,2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 50,9 хувь буюу 8,8 тэрбум төгрөг 4 ба түүнээс дээш сартай авлага эзэлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын 2 дугаар сарын мэдээгээр нийт 2066.5 сая төгрөг төлөвлөснөөс 1646.7 сая төгрөг зарцуулж, 419.7 сая төгрөг хэмнэгдсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 468.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /Өссөн дүнгээр, сая төгрөгөөр/

	2010_2 сар	2011_2 сар	Өсөлт/ Бууралт
Тэтгэврийн	2 269.2	2 880.1	610.9
Тэтгэмж, төлбөрийн	64.2	66.4	2.2
Нийт дүн	2 333.3	2 946.5	613.1

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага /Өссөн дүнгээр, сая төгрөгөөр/

	2010_2 сар	2011_2 сар	Өсөлт/ Бууралт
Ажилгүйдлийн тэтгэмж	1 150.8	1 510.11	359.3
Сургалтын зардал	12.7	1.90	(10.8)
Нийт дүн	1 163.5	1 512.0	348.5

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Өссөн дүнгээр, сая төгрөгөөр/

	2010_2 сар	2011_2 сар	Өсөлт/ Бууралт
Эмнэлгийн эмчилгээний зардал	8 230.6	10 237.0	2 006.4
Эмийн үнийн хөнгөлөлт	98.9	295.8	196.9
Рашаан сувиллын зардал	80.1	192.1	112.0
Нийт дүн	8 409.6	10 724.9	2 315.3

Шимтгэлийн авлага /насжилтаар, тэрбум төгрөгөөр/



Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2010_02 сар	2011_02 сар	Өөрчлөлт	
			Тоогоор	Хувиар
Цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл	901.1	1318.8	417.7	146.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	277.4	327.8	50.4	118.2%
Урсгал зардлын дүн	1178.5	1646.6	468.1	139.7%